

БОЛОВСРОЛЫН ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ ДЭМЖИХ ЖИЛИЙН АЖЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 06

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дугаар захирамжаар 2023 оныг Боловсролын чанар, хүртээмжийг дэмжих жил болгон зарлаж, жилийн ажлын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдалд хяналт-шинжилгээ хийж, хэрэгжилтийн талаар удирдлагуудыг мэдээллээр хангахад оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2-т заасан аргачлалын дагуу хийлээ.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН


Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жилд хийх ажлын төлөвлөгөөг 5 чиглэлийн хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан батлуулсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг Нийгмийн бодлогын хэлтсээс жилийн эцсийн байдлаар тооцон гаргаж ирүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ирүүлсэн тайлангаас гадна холбогдох хэлтэс, агентлагаас нэмэлт тодруулга авч 38 арга хэмжээний дундаж үнэлгээгээр тооцон гаргахад 88.4 хувьтайгаар хэрэгжүүлэн ажилласан байна.

ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

Оюунлаг, МУБИС-тай хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд багш нарын мэргэжлийн онол, арга зүйг дээшлүүлэх 2 удаагийн сургалт, цахим болон танхимын сорилуудыг зохион байгуулж, 17 судлагдахууны 597 багш нар мэргэжлийн онол арга зүй мэдлэгээ дээшлүүлсэн байна. Мөн 350 сурагч, 10 чиглэлээр 10 удаагийн сорилд хамруулсны үр дүнд Дундговь аймаг ЭЕШ-2023 шалгалтын нийт шалгуулагчид өнгөрсөн жилийн дундаж оноогоо математик 9,1 оноо, монгол хэл 3,3 оноо, нийгмийн ухаан 8,2 оноо, хими 14 оноо, биологи 4,3 оноогоор ахиулж, физик өнгөрсөн жилийн амжилтаа хадгалж, 6 судлагдахуун дундаж оноогоороо улсад 1-10-р эрэмбэлэгдсэн.

Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан мэргэжлийн багш нарын багийг урамшуулах журмыг шинээр боловсруулан баталж, журмын дагуу элсэлтийн

шалгалтад амжилттай дүн үзүүлсэн 40 багшид 110.0 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.



Залуу багш нарын хүүхэд нэг бүрийг хөгжүүлж байгаа хичээлийн арга зүйн шинэ санааг эрэлхийлэх, харилцан туршлага солилцох, суралцах, багшийн ур чадвар хөгжлийг дэмжих, шилдэг арга зүй, технологийн сан бүрдүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт 1-5 жил ажилласан багш нарын дунд “САЙН ХИЧЭЭЛ-2023” арга хэмжээ зохион байгуулав. Ерөнхий боловсролын сургуулийн нийт багш нарын 27.8 хувь буюу 138 багш 1-5 жил ажиллаж байгаагаас ур чадварын уралдаанд 100 багш буюу 72.5 хувь нь, цэцэрлэгийн 99 багшийн 22 хувь буюу 22 багш оролцон, хичээл зааж арга зүйгээ харилцан солилцсон үр дүнтэй арга хэмжээ болсон.



ЕБС-ийн 2022-2023 оны хичээлийн жилийн улсын төрөлжсөн олимпиад 13 хичээлээр явагдаж нийт 731 хүүхэд оролцон мэдлэг чадвар, оюун ухаанаа сорьсон өмнөх үеийнхээс 10 хувиар өссөн сайн үзүүлэлттэй байна. Үүнээс 11 судлагдахуунд-731 суралцагч, монгол хэл-9-р ангийн анги нийтийн олимпиадад - 790, нийт 1521 суралцагч оролцжээ.



Хамгийн их зардал материал шаардагддаг техник технологийн олимпиадад оролцогч багш сурагчдад дэмжлэг 4,0 сая төгрөгийг шийдвэрлэж ажиллалаа.



Эрхүүгийн Үндэсний Судалгааны Техникийн Их Сургуульд орос хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх зуны сургалтад Сайнцагаан сумын Цэгц билиг сургуулиас 2, Баянжаргалан, Дэрэн, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 4, нийт 6 багш “Орос хэлний сургалтад орчин үеийн дэвшилтэт технологийг хэрэглэх арга зүй” сургалт, Оросын Сибирийн бүс нутгийн өв соёл, зан заншилтай танилцаж 21 хоног суралцаад ирлээ. Мөн хичээлийн судалгааны чиглэлээр Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгтэй хамтран Япон улсад Мандал сургуулийн 6 багш, нийт 13 багш, удирдах ажилтан мэргэжлээ дээшлүүлэхэд 13.8 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн.



Сайнцагаан сумын 5-р цэцэрлэг, Эрдэнэдалай, Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэгийн гадаад тоглоомын талбайг иж бүрэн тохижуулах ажлыг орон нутгийн 119.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийсэн.



Арга хэмжээний нэр: 4.1 Үндэсний бичиг үсгийн баяр-2023 хичээлээр



Зорилго: Иргэд, суралцагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварыг ахиулах



Арга хэмжээний тоо: 6



Оролцогчдын тоо: Иргэд, суралцагчид төрийн албан хаагчид-1595



Хамтрагч байгууллагууд: АЗД, АЗДТГ Хэлний бодлогын салбар зөвлөл, БШУГ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ: 5.3 сая төгрөг

Иргэд, төрийн албан хаагчдын цахим ур чадварын боловсролыг дээшлүүлэх



Төрийн албан хаагчдад цахим ур чадварын сургалтыг танхимаар 430, цахимаар 230 нийт 660 хүнд зохион байгууллаа. Мөн 2200 иргэд, төрийн албан хаагчдад цахимаар алсын хараа 2050 урт хугацааны бодлогын цахим контент сургалтыг Удирдлагын академитай хамтран зохион байгуулж гэрчилгээ олгосон. Нийт 2860 иргэн, төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ


Сумдын Эрх зүйн хөтөчүүдийг чадавхжуулах сургалтыг жил бүр танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулан чадавхжуулж, эрх зүйн сургалтыг 161 удаа 7649 хүнд буюу 16-аас дээш насны иргэдийн 23,1 хувьд, 275 удаа хууль, эрх зүйн сурталчилгааг хүргэн ажиллаж байна.



“Хууль тогтоомж сурталчлах өдөрлөг”-ийг 6 суманд зохион байгуулсан.



Нүүдэлчин Монголчуудын уламжлалт, тоглоом наадгай, өв соёл



“Нүүдэлчин Монгол-2023” СББӨ-ийн дэлхийн фестивалд 76 хүний бүрэлдэхүүнтэйгээр “Нүүдэлчин Отог”-ын тоглолт болон тайзны тоглолт, гэр музей, гар урчуудын үзэсгэлэн худалдаа, айраг, цагаан идээний үзэсгэлэн худалдаагаар оролцож, 3100 иргэнд аймаг орон нутгынхаа урлаг, соёлыг сурталчилсан.

“Уяхан замбуу тивийн наран” урлагийн их наадамд оролцогч морин хуурч, уртын дуучдыг бэлтгэх 68 сургагч багшийг бэлтгэн, “Нар нь нүүдэллэсэн аялгуу” уртын дуучид, морин хуурчдын нэгдсэн тоглолтод 3200 гаруй авьяастнуудыг оролцуулсан.

Жуулчин хүлээн авдаг малчин өрхийг зочлох үйлчилгээнд сургах



Нээлттэй Дундговь ирсонто орнуултын чуулганы аллан жуулчлалын сангийн хэлтэстүүлэг жуулчин хүлээн авдаг 2 малчин өрх ажиргалдан Ивэн аймагт шалтгалтын журмын жуулчин хүлээн авдаг 10 малчин өрхөд Эрүүл ахуйн стандарт нэмэгдлийн талаар сургалт мэдээлэл өгсөн. 11т 2023 олон улсын адал жуулчлалын үзэгдэлд жуулчин хүлээн авдаг 8 малчин өрх оржид, зочлох үйлчилгээний сургалтад хамрагдал тур оператор компаниудтай 2024 онд жуулчин хүлээн авдаг 104 өрхэд баазуулах 500 нэгж материал зориаж тэмцэлтэйн гүйцэт 47 малчин өрх сургалтад хамрагдсан.



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөний 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан аргачлалын дагуу 5 чиглэлийн хүрээнд төлөвлөсөн 38 арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу суурь түвшин, зорилтот түвшиндээ хүрсэн эсэхийг харьцуулан хяналт-шинжилгээг хийж дэвшүүлсэн зорилт буюу Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг 88.4 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж байна.

Хэрэгжилтийн байдлаас харахад зорилтот түвшиндээ хүрээгүй арга хэмжээнүүд

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
1	Физикийн хичээлийн сургалтын Моно Цүкири хэрэглэгдэхүүнтэй болох	Багцын тоо өссөн дүнгээр	Физикийн хичээлийн сургалтын Моноцүкири хэрэглэгдэхүүний ашиглалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх нээлттэй туршилтуудыг Сайнцагаан сумын Говийн ирээдүй, Мандал, Эрдмийн далай сургуулиуд “Боловсролын чанар, хүртээмжийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд зохион байгуулж иргэд олон нийтэд нээлттэй танилцууллаа.	0
2	Цэцэрлэгийн гадна тоглоомын талбайд стандартад нийцсэн элсний талбай байгуулах	Элсний талбайтай болсон цэцэрлэгийн тоо	Аймгийн хэмжээний 22 цэцэрлэгээс Сайнцагаан сумын 6,7,8-р цэцэрлэг, Сайхан-Овоо, Луус, Өндөршил, Говь-Угтаал сумдын цэцэрлэгүүд шинээр элсний талбайг гадна тоглоомын талбайн MNS65582015 стандартын шаардлагад нийцсэн элсний талбай болон тагтай элсний хайрцгийг улсын төсөв, орон нутгийн хөгжлийн сан, иргэдийн хандив тусламжаар байгуулсан байна. Энэ арга хэмжээ нь аймгийн цэцэрлэгүүдийг элсний стандартын талбайтай болох эхлэлийг тавьсан үр дүнтэй арга хэмжээ боллоо. Мөн Сайнцагаан сумын 3,4-р цэцэрлэг, Хулд, Дэлгэрцогт сумын цэцэрлэгүүд хуучин элсний талбайгаа засварлан сайжруулж элсний талбайтай цэцэрлэг 11 буюу 50 хувь нь элсний талбайтай болоод байна.	50

3	Цэцэрлэгийн анги танхимыг хивс болон бусад эрүүл ахуйн шаардлага хангасан дэвсгэр чийг татахгүй дулаан хадгалдаг материалаар сайжруулах	Стандартад нийцсэн дэвсгэртэй болсон анги танхимын тоо	Сайнцагаан сумын 1,3,4,8-р цэцэрлэгүүдийн 15 ангийн унтлагын өрөө, Өндөршил сумын 4 ангийн унтлагын өрөө болон урлаг зааланд стандартад нийцсэн дрож, дэвсгэрийг иргэдийн хандив тусламж болон, Тогтвортой хөгжлийн боловсролын төслөөр шийдвэрлүүлсэн байна. Энэ арга хэмжээ нь анги танхимыг стандартад нийцсэн дэвсгэртэй болгох, хүүхэд дулаан тохитой орчин хөгжих таатай орчин бүрдээд байна.	50
4	Технологийн хичээлд юнимат багаж хэрэгслийг ашиглан цэцэрлэгт модон тоглоом хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх	Хэрэглэгдэхүүний төрөл, тоо	Өлзийт сумын сургуулийн технологийн багш сурагчидтайгаа хамтран юнимат тоног төхөөрөмжийг ашиглан "12 жил, эвлүүлдэг тоглоом, бэлэг дурсгалын зүйл үйлдвэрлэж сургалтын хэрэглэгдэхүүний танилцуулгыг цэцэрлэгийн эрхлэгч 22, аймгийн 14 сургуульд танилцууллаа. Нэг багц бүтээгдэхүүний үнэ 120,0 мянган төгрөгөөр гарч байгаа бөгөөд 22 цэцэрлэг 12 төрлийн 120 модон хэрэглэгдэхүүний захиалгаа өгч хийлгэж байгаа бөгөөд 2 цэцэрлэгийн 40 ширхэг тоглоомыг нийлүүлж, сургалт үйл ажиллагаандаа ашиглаж байна.	50
5	Цэцэрлэгт анги бүлгүүд ариутгагчтай болох	Ариутгагчийн тоо	Сайнцагаан сумын 7-р цэцэрлэг, Өндөршил, Баянжаргалан, Говь угтаал, Сайхан овоо сумын цэцэрлэгүүд тус бүр 4 бүлэгтээ 20 сойз ариутгагчийг авч хэрэглэж байгаа нь хүүхдүүдийн амны хөндийн эрүүл ахуйг дэмжсэн сайн үзүүлэлт боллоо.	50
6	"Цахим үндэстэн-E-Nation" зорилтын хүрээнд мэдээллийн технологийн чиг үүрэг бүхий албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулах замаар иргэд, төрийн албан хаагчдын цахим ур чадвар /тоон бичиг үсэг-Digital literacy/-ийн боловсролыг дээшлүүлэх	Мэдээллийн технологийн чиг үүрэг бүхий албан хаагч болон цахим ур чадварыг дээшлүүлэхээр бэлтгэгдсэн сургагч багшийн тоо	Аймгийн насан туршийн боловсролын байгууллагатай хамтран цахим ур чадварын 16 сургагч багш, 15 сумдад мэдээллийн технологийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр төлөвлөгөө боловсруулсан. Төлөвлөгөөний дагуу 4-р улиралд сургалтууд зохион байгуулагдана. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран аймгийн "ХУРДАН" цахим үйлчилгээний ахлах мэргэжилтэнг цахим ур чадварын сургагч багшаар бэлтгэх төрийн байгууллагуудад цахим ур чадварын сургалтыг зохион байгуулж байна.	70
		Бүх нийтийн цахим ур чадвар, тоон бичиг үсэгтэн болох чиглэлээр зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	Танхимаар 20, цахимаар 7 нийт 27 удаагийн сургалт зохион байгуулсан.	
		Цахим ур чадварын сургалтад хамрагдсан иргэдийн тоо	2023 оны 10 сарын байдлаар танхимаар 430, цахимаар 230 нийт 660 төрийн албан хаагчдад цахим ур чадварын сургалтыг зохион байгууллаа. Мөн 2200 иргэд, төрийн албан хаагчдад цахимаар алсын хараа 2050 урт хугацааны бодлогын цахим контент сургалтыг Удирдлагын академитай хамтран зохион байгуулж гэрчилгээ олгосон. Нийт 2860 иргэн, төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан.	

Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал

№	Үйл ажиллагааны чиглэл	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь					Дундаж хувь	
			100	90	70	50	30		0
1	Боловсролын салбарын багш ажилтан, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр	7	6		1			-	95.7
2	Сурагчдын хөгжил оролцоог нэмэгдүүлэх, сурлагын амжилтыг ахиулах чиглэлээр	6	5					1	83.3
3	Сургалтын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр	7	3			4		-	71.4
4	Иргэд олон нийт төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах	7	6		1			-	95.7
5	Бүх нийтийн боловсролыг дэмжих, соён гэгээрүүлэх, сургалт нөлөөллийн чиглэлээр	11	9		1	1		-	92.7
6	Дүн	38	29	-	3	5		1	88.4

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 284.7 сая төгрөг зарцуулахаар төсөвлөж жилийн эцсийн байдлаар 1199.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийн хамт хүснэгтээр харуулбал:

№	Үйл ажиллагааны чиглэл	Төсөвлөсөн хөрөнгө /сая төгрөг		Зарцуулсан хөрөнгө /эх үүсвэр тус бүрээр/			Дүн
		УТ	ОНТ	УТ	ОНТ	ОУТ, хандив	
1	Боловсролын салбарын багш ажилтан, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр	7.2	172.5	10.0	140.7		150.7
2	Сурагчдын хөгжил оролцоог нэмэгдүүлэх, сурлагын амжилтыг ахиулах чиглэлээр	8.0	86.0	6.0	10.0	2.0	18.0
3	Сургалтын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр	225.0	150.0	617.8	113.7	163.7	895.2
4	Иргэд олон нийт төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах		30.0		27.7		27.7
5	Бүх нийтийн боловсролыг дэмжих, соён гэгээрүүлэх, сургалт нөлөөллийн чиглэлээр	44.5	49.1	52.7	30.2	25.2	108.1
6	Дүн	284.7	487.6	686.5	322.3	190.9	1199.7

Төсөвлөсөн хөрөнгийн хэмжээг зарцуулсан хөрөнгийн хэмжээтэй харьцуулан графикаар харуулбал:



Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад 2 удаа хяналт-шинжилгээ хийхэд эхний хагас жилд 66.1 хувь, 10 сарын байдлаар 72.2 хувь байсан.

Жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг ажлын хэсгийн хурлаар 1 удаа сонсож цаашид эрчимжүүлэх талаар зөвлөмж өгч ажилласны үр дүнд жилийн эцсийн байдлаар 88.4 хувьтай үнэлэгдэж эхний хагас жилийн хэрэгжилтээс 16.2 хувиар ахисан байна.

ХЯНАСАН :

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА *Д. Даариймаа*

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Э.Одончимэг* Э.ОДОНЧИМЭГ

